

ТА ИНТЕРНЕТ БАНК БОЛОН 319708, 319709
УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ
ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.

2022.02.21

Онцлох мэдээ

- Хятад улсын шинэ орон сууцны үнэ 1-р сард өнгөрсөн 9-р сараас хойш удаа өсжээ. Томоохон 70 хотын шинэ орон сууцны дундаж үнэ 12-р сарын 0.2%-ийн уналттай харьцуулахад 0.1%-иар нэмэгдсэн байна.
- Бямба гарагт Дэлхийн банкны группийн удирдах зөвлөл Украин улсад ойрын болон урт хугацааны санхүүжилтийн төлөвлөгөөний нэг хэсэг болгон 350 сая ам.долларын санхүүжилт олгоход бэлэн байгаа бөгөөд 3-р сарын эцэс гэхэд хэлэлцэх тухай мэдэгдэв.

Валютын зах зээл

Валютын зах зээл энэ долоо хоногийг Зүүн Европ дахь хурцадмал байдлыг анхааралтай ажиглан эхлүүлэв. Эрсдэл багатай иен 2 долоо хоногийн оргил цэгээс холгүй байх зуур Украины дайн болон Европын эрчим хүчний аюулгүй байдал, эзийн засгийн үр дагаваруудаар еврогийн ханш дээшиллээ. Еврогийн ханш 0.12% дээгүүр 1.1334 хүрсэн бол иен 115.05-тай тэнцэж, 2 долоо хоногийн доод түвшин болох 114.78 руу чиглэж байсан хөдөлгөөнөө түр зогсоов.

Өнгөрөгч Баасан гарагт Оросын дэмжлэгтэй салан тусгаарлагчид зүүн Украин дахь салан тусгаарласан газар нутгаа нүүлгэн шилжүүлэх болсноо гэнэт мэдэгдэж улмаар рублийн ханш 77-г сэтлэн суларсан байна. Тус өдөр рубль ам.долларын эсрэг 1.3% буурч 77.29 хүрчээ.

Алтны зах зээл

Алтны ханш Даваа гарагийн эхэнд хүрээд байсан 8 сарын дээд цэгээс ухарсан нь АНУ-ын ерөнхийлөгч Оросын талтай Украины зөрчилдөөний талаар уулзахад бэлэн байгаагаа мэдэгдсэнээр металлын эрэлт буурсантай холбоотой юм. Өглөөний байдлаар 1 унц алтны спот ханш 0.2% бууралттай 1,893.80 ам.доллар байсан бөгөөд 6 сарын 3-наас хойших дээд цэг 1,908.02 ам.доллараас унаад байна. АНУ-ын алтны фьючерс GCv1 1,898.60 ам.доллар дээр тогтвортой байна.

Зэсийн зах зээл

Орос-Украины хурцадмал байдал намжих шинжтэй болсноор эрсдэл өндөр хөрөнгүүдэд дэмжлэг үзүүлсэн бөгөөд ам.долларын ханш суларсан зэрэг шалтгаануудаар Лондонгийн зэсийн ханш өслөө. Лондонгийн Металлын Биржийн зэсийн фьючерс 0.3% өсөж 9,985.50 ам.долларт арилжаалагдах зуур Шанхайн Фьючерсийн Бирж дээрх зэсийн фьючерс 71,540 юань (\$11,312.64)-д тогтуун байлаа. Өнгөрсөн долоо хоногийн ШФБ-ийн агуулах дээр хянагдсан зэсийн нөөц 27.9% нэмэгдэж 136,300 тонн болжээ.

Газрын тосны зах зээл

ОХУ болон Украины маргаан газрын тосны ханш нэг

Валют	Ханш	24ц өөрч.
EUR/USD	1.1356	0.30%
USD/CNY	6.321	0.19%
USD/RUB	77.3366	0.01%
USD/JPY	115.03	0.02%
USD/KRW	1195.8	0.00%
AUD/USD	0.7201	-0.16%
GBP/USD	1.3615	0.00%

Индекс	Нэгж	24ц өөрч.
Dow Jones	34079.2	-0.68%
S&P 500	4348.9	-0.72%
NASDAQ	13548.1	-1.23%
FTSE 100	7513.6	-0.32%
Nikkei 225	26855.0	-0.98%
DAX	15042.5	-1.47%
Hang Seng	24140.3	-0.77%

Метал	Ханш (USD)	24ц өөрч.
Алт	1895.92	-0.13%
Мөнгө	23.82	-0.41%
Нүүрс (Чин хуанг дао)	163.74	0.02%
Зэс (LME)	9956	0.27%
Төмрийн хүдэр	671.00	-0.59%
Газрын тос (NYME)	90.46	-0.67%

LIBOR	Хүү	24ц өөрч.
US 1M LIBOR	0.17%	5.57%
US 3M LIBOR	0.48%	-0.30%
US 6M LIBOR	0.78%	1.00%
US 12M LIBOR	1.29%	-0.23%

Бонд	Хүү	24ц өөрч.
US Treasury 10Y	1.93%	0.00%
UK Treasury 10Y	1.38%	-5.81%
GE Treasury 10Y	0.19%	-16.88%
JP Treasury 10Y	0.21%	-4.17%

Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж	24ц өөрч.
Чингис	5.13%	12/5/2022	3.06%	0.10%
Гэрэгэ	5.63%	5/1/2023	3.33%	-0.01%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	4.58%	-0.17%
Хуралдай	8.75%	3/9/2024	3.98%	-0.09%
ММС	9.25%	4/15/2024	23.75%	0.10%
МИК 2024	8.85%	8/2/2024	11.34%	0.00%
Номад	5.13%	4/7/2026	4.72%	-0.06%
Монгол 27	3.50%	7/7/2027	4.97%	-0.09%
Монгол 31	4.45%	7/7/2031	5.40%	-0.06%
Самурай JPY	1.52%	12/25/2023	0.05%	-0.02%

Хувьцаа	Ханш	24ч өөрч.
Turquoise Hill Resources	20.43	-0.49%
Mongolian Mining Corp	2.15	2.38%
Erdene Resource Dev	0.44	-2.25%
Centerra Gold	11.39	-1.04%

Макро эдийн засаг (Монгол)	Огноо	Дүн
Инфляцийн түвшин	2022 (I)	14.6%
Бодлогын хүү	2022 (I)	6.5%
Банк хоорондын зах зээлийн хүү	2021 (XII)	6.08%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2022 (I)	7.78%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2022 (I)	2.26%
Зээлийн дундаж хүү (төг)	2022 (I)	15.5%
Зээлийн дундаж хүү (валют)	2022 (I)	9.21%

Ханшийн таамаглал

Валют	Q1 22	Q2 22	Q3 22	Q4 22	2023
EUR/USD	1.12	1.13	1.15	1.16	1.19
GBP/USD	1.35	1.36	1.37	1.38	1.40
USD/CNH	6.38	6.35	6.40	6.41	6.28
USD/JPY	115	115	116	116	115
USD/RUB	76.0	75.0	75.0	73.0	75.0

Түүхий эд

Алт	1800	1750	1707	1690	1650
Зэс	9620	9350	9400	9500	9550
Нүүрс	131.5	105.0	92.5	84.0	71.5

Эдийн засгийн голлох тоо мэдээ эх сурвалж: Блүүмбэрг

Өмнөх өдрийн үр дүн	Үр дүн	Таам.	Өмнөх
UK Retail Sales YY	9.1%	8.7%	-0.9%
UK Retail Sales MM	1.9%	1.0%	-3.7%
US Existing Home Sales	6.5M	6.1M	6.18M
JP CPI, Overall Nationwide	0.5%	-	0.8%
JP CPI, Core Nationwide YY	0.2%	0.3%	0.5%

Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
UK Flash Manufacturing PMI	17:30	-	57.3
FR Markit Mfg Flash PMI	16:15	-	55.5
GE Markit Mfg Flash PMI	16:30	-	59.8
JP Jibun Bank Mfg Flash PMI	8:30	-	55.4

Маргааш хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
GE Ifo Curr Conditions New	17:00	96.6	96.1
GE Ifo Business Climate New	17:00	96.5	95.7
US Markit Svcs PMI Flash	22:45	-	51.1
US Markit Mfg PMI Flash	22:45	53.0	51.2
US Consumer Confidence	23:00	109.8	113.8

орчим ам.доллараар өсөхөд нөлөөллөө. Европын Холбооны ерөнхийлөгч хэрвээ ОХУ дайн эхлүүлвэл дэлхийн санхүүгийн зах зээлд нэвтрэх болон экспорт хийх боломжийг хаана гэж дахин анхааруулаа. Brent газрын тосны үнэ 1.4 хувь өсөж 94.88 ам.долларт арилжаалагдаж байна.

Бондын зах зээл

АНУ-ын засгийн фьючерс Азийн захын нээлтээр өслөө. Геополитикийн зөрчилдөөнөөс шалтгаалж 4 долоо хоногийн дараа анх удаа долоо хоногийн өсөлт үзүүлээд байсан юм. АНУ холбоотнууддаа хэрвээ ОХУ Украин руу довтолбол Киевээс гадна олон хот руу довтлох байх гэсэн анхааруулга өгсний дараа Австралийн бондууд өслөө. АНУ-ын засгийн бондын фьючерс 3/32 өсөж 126 3/4 болсон бөгөөд Баасан гарагт 1/4 өсөөд байсан юм.

Хөрөнгийн зах зээл

Nasdaq100, S&P500 болон европын хувьцаанууд уналтаа нөхөж, өсөлт үзүүлсээр байгаа бол Азийн хувьцаанууд өссөн ч ханшийн уналтыг нөхөөгүй байна. Хөрөнгийн зах зээл ОХУ болон Украины маргаан хэрхэн шийдэгдэхийг анхааралтай хүлээж байна. Франц улсын зүгээс ОХУ болон АНУ-ууд хэлэлцээрийн агуулгыг зөвшөөрсөн гэж мэдээллээ. Гэхдээ хэлэлцээр зөвхөн ОХУ Украин руу ямар нэгэн халдлага хийгээгүй үед эхэлнэ гэж хэлжээ.

Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдалд ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт харуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин үг и-мэйлд харуу илгээнэ үү.